



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 13 едер

Дугаар 4/519

Ховд

Газар чөлөөлөх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Жаргалант сумын нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүй дур мэдэн хашаа, объект барьсан, зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү татсан иргэн, аж ахуй нэгж, байгууллагын газрыг чөлөөлөх ажлыг зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Баярсүх/, Ховд аймаг дахь Цагдаагийн газрын дарга / Б.Батзаяа/, Жаргалант сумын Засаг дарга /С.Гантөмөр/ нарт тус тус үүрэг болгосугай.

2. Газар чөлөөлөхтэй холбогдон гарах зардлыг Газрын тухай хуулийн 57.4 дэх заалтын дагуу зохих зөвшөөрөлгүй газар эзэмшиж ашигласан иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас гаргахыг Жаргалант сумын Засаг дарга /С.Гантөмөр/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т. Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА   
Б.ДҮГЭРЖАВ